



ОРОН СУУЦ НИЙТИЙН АЖ АХУЙН УДИРДАХ ГАЗАР ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 03 сарын 15 өдөр

Дугаар А/36

Улаанбаатар хот

“Барилгын норм ба дүрэм” сэдэвт сургалтад
хамруулах, зардал гаргах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2, 10 дахь заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 33 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар” ОНӨААТҮГ-ын дүрмийн 8.3.11 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын Хөдөлмөрийн дотоод журмын 8.2.4 дэх заалтын дагуу 2019 оны 03 дугаар сарын 18, 19-ний өдрүүдэд зохион байгуулагдах “Барилгын норм ба дүрэм” сэдэвт сургалтад тус газрын инженерүүдийг хамруулсугай.

2. Сургалтын хөтөлбөрийг 1 дүгээр хавсралтаар, сургалтын зардлыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Сургалтын зардалд 1519000 /нэг сая таван зуун арван есөн мянган/ төгрөгийг үйл ажиллагааны зардлаас гаргахыг Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга /И.Урантогос/-д зөвшөөрсүгэй.

4. Тус сургалтад ажилтнуудыг хамруулахыг Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга /Л.Намжилмаа/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.БАТСАЙХАН

Орон сууц нийт ийн аж ахуйн удирдах газрын даргын 2019 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн ...136... дугаар тушаалын 2... дүгээр хавсралт



**“БАРИЛГЫН НОРМ БА ДҮРМҮҮД” СЭДЭВТ
СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР**

Сургалтын зорилго: Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газрын нийт инженерүүдэд барилгын норм ба дүрмийн мэдлэг олгоход энэхүү сургалтын зорилго оршино.


Сургалтын хугацаа: 2019 оны 03 дугаар сарын 18, 19-ний өдрүүдэд

Хамрагдах ажилтан: ОСНААУГ-ын 100 инженер

Сургалтын танхим : АBB төв

Д/д	Хичээлийн сэдэв	Агуулга	Огноо	Хугацаа	Багш
1	Сургалтын бүртгэл		2019.03.18	09:50	ХНССХМ Д.Одончимэг
2	Нээлтийн үйл ажиллагаа		2019.03.18	10:00- 10:10	Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газрын дарга Ж.Батсайхан
Гадна дулаан хангамж, дотор халаалтын системийн талаар					
3	Дулааны сүлжээ БНБД 41-02-13	Гадна дулааны шугам сүлжээг шинээр төлөвлөх, шинэчлэн солих ажлын зураг төлөвлөх талаар	2019.03.18	10:10- 11:10	Зөвлөх инженер А.Цогт
4	Тоног төхөөрөмж, дамжуулах хоолойн дулаан тусгаарлалт БНБД 41-04-13	Шугам сүлжээний дулаалгын материалын сонголт, тооцооны талаар	2019.03.18	11:10- 12:10	Зөвлөх инженер А.Цогт
5	Цайны завсарлага			12:10- 12:30	ХНССХМ Д.Одончимэг
6	Халаалт, агаар сэлгэлт, кондиционер БНБД 41-01-11	Дотор халаалтын системийн ажлын зураг төлөвлөх	2019.03.18	12:30- 13:30	Зөвлөх инженер А.Цогт
Гадна ус хангамж, дотор ус хангамж ариутгах татуургын талаар					
7	Ус хангамж, гадна сүлжээ ба байгууламж БНБД 40-02-16	Гадна ус хангамж ариутгах татуурга, дотор ус хангамж ариутгах татуургын систем шинээр төлөвлөх болон шинэчлэн солих	2019.03.19	09:00- 10:00	Зөвлөх инженер О.Эрдэнэбаатар
8	Ариутгах татуурга. Гадна сүлжээ ба байгууламж БНБД 40-01-14		2019.03.19	10:00- 11:00	Зөвлөх инженер О.Эрдэнэбаатар
9	Цайны завсарлага		2019.03.19	11:00- 11:20	ХНССХМ Д.Одончимэг
10	Ус хангамж, ариутгах татуургын гадна сүлжээ, барилга байгууламж БНБД 40-04-16		2019.03.19	11:20- 12:20	Зөвлөх инженер О.Эрдэнэбаатар
11	Барилга доторхи ус хангамж, ариутгах татуурга БНБД 40-05-16		2019.03.19	12:20- 13:20	Зөвлөх инженер Д.Мягмар
12	Дотор сантехникийн систем БНБД 40-06-16		2019.03.19	13:20- 14:20	Зөвлөх инженер Г.Эрдэнэцэцэг

Орон сууц нийт ийн аж ахуйн удирдах газрын
даргын 2019 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн
.../26... дугаар тушаалын 2 дугаар хавсралт



“БАРИЛГЫН НОРМ БА ДҮРМҮҮД” СЭДЭВТ
СУРГАЛТЫН ЗАРДАЛ

Д/д	Зардлын нэр	Тоо ширхэг	Нэгжийн үнэ /төгрөг/	Нийт зардал
1	Сургагч багшийн төлбөр	4 багш 8 цаг	66500	532000
2	Сургалтын танхим түрээс	9 цаг	80000	720000
3	Кофе	200 ширхэг	350	70000
4	Печень	10 хайрцаг	5000	50000
5	Чихэр	3 кг	15000	45000
6	Нэг удаагийн аяга	200 ширхэг	50	10000
7	Ус	150 ширхэг	600	90000
8	Нэг удаагийн халбага	1 уут	2000	2000
	Нийт			1519000